



**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ**

**Улаанбаатар хот
2017 оны 03 сарын 25-ны өдөр**

“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

2017 оны 03 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14 цагт Улаанбаатар Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг, 14 давхар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхимд хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. “Шивээ Овоо” ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан, Аудитын хорооны дүгнэлт
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайлан болон 2017 оны зардлын төсвийг батлах тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн сонгох
5. Ногдол ашгийн тухай
6. Компанийн эд хөрөнгө актлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах эцсийн өдрийг 04 дүгээр сарын 27-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын холбогдох материалтай 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн “Шивээ Овоо” төлөөлөгчийн газар, харьяа брокер дилерийн компани дээрээ ирж танилцан хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Хурал хуралдуулах газрын хаяг:

Улаанбаатар Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг, 14 давхар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхим

Лавлах утас:

“Шивээ Овоо” ХК-ийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газар, утас: 11458940

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

- 1.1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланд дүгнэлт өгөх (Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар, ТУЗ-ийн дарга Ц.Түмэнцогт)
- 1.2. Компанийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах (Хэлтсийн дарга С.Одбаяр, ТУЗ-ийн Аудитын хорооны дарга А.Батзориг)
- 1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах (ТУЗ-ийн дарга Ц.Түмэнцогт)
- 1.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх (ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Ганболд)
- 1.5. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэх (Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар)
- 1.6. Компанийн эд хөрөнгө актлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх (Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал Э.Цасчихэр)

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДОХ ТАНИЛЦАЖ
БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. “Шивээ Овоо” ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайлан
2. “Шивээ Овоо” ХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан санхүүгийн тайлан, Аудитын хорооны дүгнэлт
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайлан болон 2017 оны зардлын төсвийн төсөл
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 11.5.1 дэх зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хурлын танхимд хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.
Үүнд:

2.1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланд дүгнэлт өгөх (Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар, ТУЗ-ийн дарга Ц.Түмэнцогт)

2.2. Компанийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах (Хэлтсийн дарга С.Одбаяр, ТУЗ-ийн Аудитын хорооны дарга А.Батзориг)

2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах (ТУЗ-ийн дарга Ц.Түмэнцогт)

2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх (ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Ганболд)

2.5. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэх (Гүйцэтгэх захирал О.Отгонбаатар)

2.6. Компанийн эд хөрөнгө актлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх (Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал Э.Цасчихэр)

3. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг нэгдүгээр хавсралтаар баталж 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөрт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг хоёрдугаар хавсралтын дагуу баталж 2017 оны 03 дугаар сарын 20-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэж мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудлаар "Санал авах хуудас"-ны загварыг тавдугаар хавсралтаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох "Санал авах хуудас"-ны загварыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

5. Хуралд бэлтгэх зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

- 1) Хурал даргалагч:
Ц.Түмэнцогт: Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
- 2) Хурал зохион байгуулах комиссын дарга:
О.Отгонбаатар /Гүйцэтгэх захирал/
- 3) Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
Ж.Батмөнх /Захиргаа хүний нөөцийн бодлогын хэлтсийн дарга /
Г.Мөнхцэцэг /Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/
А.Энхгэрэл /Хуулийн зөвлөх/
Д.Золзаяа / Захиргааны мэргэжилтэн/
- 4) Хурал зохион байгуулах тооллогын комиссын дарга.
С.Одбаяр / ерөнхий нягтлан бодогч/
- 5) Хурал зохион байгуулах тооллогын комиссын гишүүд:
Ц.Батмандах Төлөөлөгчийн газрын дарга/
н.Эрдэнэ-Очир /XXX-ийн менежер/

6. Санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөр тогтоосугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийг 2017 оны 03 сарын 25-ны өдрөөс эхлэн "Шивээ Овоо" ХК-ийн Төлөөлөгчийн газар болон харьяалагдах брокер диллерийн компаниар дамжуулан танилцахыг дурдсугай

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг брокер дилерийн компаниудаар дамжуулан хүлээн авах эцсийн хугацааг 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгосугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал О.Отгонбаатарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮМЭНЦОГТ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны
 .03 дугаар сарын 17-ны өдрийн 02 тоот
 тогтоолын тавдугаар хавсралт

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар
 Санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /брокер, диллерийн компани/

Брокерийн овог нэр

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол”ХХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан
1	Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланд дүгнэлт өгөх		
2	Компанийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах		
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах		
4	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх		
5	Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэх		
6	Компанийн эд хөрөнгө актлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх		

Брокерийн/...../

гарын үсгийн тайлал

Хувьцаа эзэмшигчийн/...../

гарын үсгийн тайлал

2017 оны сарын-ны өдөр

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017
оны 02 дугаар сарын 17-ны өдрийн
02 тоот тогтоолын зургаадугаар хавсралт



“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар
ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал авах хуудас

Хувьцаа эзэмшигчийн овог

.....нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо:.....Кумулятив саналын тоо

Бүртгэсэн / брокер, диллерийн компани /

Брокерийн овог

.....нэр.....

“Шивээ Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг 14 давхар “Эрдэнэс Монгол”ХХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.

	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийн овог нэр	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
	Ердийн гишүүн	
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
	Хараат бус гишүүн	
1		
2		
3		
4		

Брокерийн/...../

гарын үсгийн тайлал

Хувьцаа эзэмшигч...../...../

гарын үсгийн тайлал

2017 оны-р сарынөдөр

**“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН,
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

Үндсэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа

2016 оны гүйцэтгэлээр 7,214.5 мянган.м³ хөрс хуулж (тээвэртэй 5,427.7 м.м3, тээвэргүй 1,786.8 м.м3) 1,961.4 мянган тонн нүүрс олборлон 1,880.9 мянган тонн нүүрс борлуулж, хөрс хуулалтын төлөвлөгөө 80.8 хувь, нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөө 96.5-100.6 хувийн биелэлттэй байна. Тээвэртэй хөрс хуулалт 77.9 хувь, тээвэргүй хөрс хуулалт 91.2 хувийн тус тус биелэлттэй байна. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт, борлуулалтын хэмжээ 103.5-112.9 хувиар, хөрс хуулалт 102.4 хувь, нийт уулын цулын хэмжээ 105.6 хувиар тус тус биелсэн байна.

Нүүрс борлуулалтын хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 96.5 хувь буюу 69.1 мянган тонноор тасарч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 103.5 хувь буюу 63.1 мянган тонноор давсан байна.

Өнгөрсөн оны мөн үед 1817.8 мян.тн нүүрс борлуулж 37428.9 сая төгрөгийн зардал гаргаж нэгжийн өртөг 18,663.5 төгрөг байсан бол 2016 онд 38,087.2 сая төгрөгийн зардал гаргаж нэгжийн өртөг 20,249.8 төгрөг болсон. Өөрөөр хэлбэл өмнөх оны мөн үеэс нэгжийн өртөг 4.2 хувь буюу 1586.3 төгрөгөөр өссөн.

Уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нүүрс олборлолт	мян.тн	1950	1961.4	101%	11.4
Нүүрс борлуулалт	мян.тн	1950	1880.8	96%	-69.2
Хөрс хуулалт	мян.м ³	8392	7214.5	86%	-1177.5
Шидэлт	мян.м ³	3110	2033.7	65%	-1076.3
Нийт уулын цул	мян.м ³	12751.9	11532.6	90%	-1219.3
Авахад бэлэн нүүрсний нөөц	мян.тн	320	50	16%	-270

Нийт уулын цулын 63 хувийг хөрс хуулалт, 18 хувийг дахин шидэлт, 21 хувийг нүүрс олборлолт, борлуулалт эзэлж байна. Сар бүр 100.0 мян.тн нүүрсний шилжих нөөцтэй байхаар зорилго тавин ажилласнаас гүйцэтгэлээр 2017 оны 1-р сард 50,0 мян.тн авахад бэлэн нүүрсний нөөцтэй шилжсэн. 2016 онд хөрсний төлөвлөгөө тасарсан нь өрөмдлөгө тэсэлгээний ажлын удаашрал, хөрс тээврийн автосамосвалуудын эвдрэл саатал их байснаас шалтгаалсан. Ээлж тутамд 22 автосамосвал гарах төлөвлөгөөтэй байснаас ээлжинд 12-17 автосамосвал гарч байсан нь хөрс хуулалтын ажилд муугаар нөлөөлсөн. Уурхайн гүн 90-100 метрт хүрсэн. Сүүлийн 10 жилийн хугацаанд хөрс хуулалтын коэффициент тасралтгүй өсч өнөөдрийн байдлаар 4,2 тн/м³ болсон байна.

Нүүрс борлуулалтын орлогын талаар: 2016 онд 1,880.9 мянган тонн нүүрс борлуулах төлөвлөгөөгөө 3.5 хувиар тасраад байна. Нүүрс борлуулалтын орлого 42,744.3 сая төгрөг байлаа.

“ДЦС-IV” компанид нийлүүлсэн нүүрсний жилийн дундаж илчлэг 2942 ккалори/кг буюу нийлүүлэх нүүрсний стандарт илчлэг 3030 ккал/кг нийт дүнгээрээ 732.8 сая төгрөгийн олох боломжоо алдсан байна. Олборлосон нүүрсний илчлэг дундажаар 2016 оны 1-р улирлын байдлаар нүүрсний дундаж илчлэг 2966.0 ккал/кг, 2-р улиралд 2915.3 ккал/кг, 3-р улиралд 2919.7 ккал/кг, 4-р улиралд 2966.7 ккал/кг гарсан байна.

Хэрэглэгчдийн хувьд нийт нүүрсний 86.8 хувийг буюу 1,631.1 мянган тонн нүүрс ДЦС-4 ХК-д борлуулсан бөгөөд Бор-Өндөр УБҮ 37.6 мянган тонн, УБТЗ 39.0 мянган тонн, Дорноговийн ДС 32.7 мянган тонн тус тус худалдан авсан.

Хэрэглэгчдээр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэсээ ДЦС-4 ХК-ийн худалдан авалт 21.0 мянган тонноор, Дорноговийн ДС 3.76 мянган тонноор тус тус буурч, Амгалан ДС 48.4 мянган тонноор, Налайх ДС 7.2 мянган тонноор, УБТЗ-ийн худалдан авалт 4.7 мянган тонноор, Бор-Өндөрийн УБҮ-ийнх 5.2 мянган тонноор Чандман бадрал 12.3 мянган тонноор тус тус өссөн байна.

Нийт нүүрснийхээ 97.5 хувийг доорх 8 хэрэглэгчид борлуулсан байна.

Нүүрс борлуулалтын зах зээлийн томоохон хэрэглэгчдэд нийлүүлж буй нүүрсний хэмжээг үзүүлбэл / мянган тонноор /

ДД/д	Хэрэглэгчид	2015 оны гүйцэтгэл	2016 оны төлөвлөгөө	2016 оны гүйцэтгэл	Дүнд эзлэх хувийн жин
1.	ДЦС-IV ТӨХК	1652.1	1680.0	1631.1	86.85
2.	УБ Төмөр зам	34.3	45.0	39.0	2.08
3.	Бор өндөр УБҮ	32.4	38.0	37.6	2.00
4.	Дорноговь ЭХНҮ	34.4	33.0	32.7	1.74
5.	Чандмань бадрал ЭХНҮ	0	28.4	12.3	0.65
6.	Налайх ДС	5.9	10.0	13.1	0.70
7.	Говьсүмбэр	12.2	14.0	14.2	0.76
8.	Амгалан ДС	0.0	46.7	48.4	2.58
9.	Бусад	46.5	54.9	49.7	2.65
10.	Дүн	1817.8	1950.0	1878.1	100.0

2016 оны байдлаар манай нүүрс борлуулалтын зах зээлд Амгалангийн ДС томоохон хэрэглэгч болж нэмэгдсэн. Тус станцад нүүрс нийлүүлэхийн тулд хатаах, шигших зэрэг нэмэлт боловсруулалт хийж байна.

ХОЁР. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨРТӨГ ЗАРДЛЫН ТАЛААР

2016 оны гүйцэтгэлээр нүүрс борлуулалтын нийт зардал төлөвлөсөн хэмжээнээс 16.7 хувь буюу 7,662.8 сая төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 12.3 хувиар буюу 4161.4 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт гарч байна.

Энэ хугацаанд нэг тонн нүүрсийг 18,780.4 төгрөгөөр олборлон 22,725.8 төгрөгөөр борлууллаа. Нүүрс борлуулалтын нэгж тутмаас 293.1 төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс борлуулалтын нэгж үнэ дундажаар 1953.2 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн уулын цулын нэгжийн өртөг төлөвлөсөн хэмжээнээс 10.9 хувь буюу 27.5 төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеийн түвшингөөс 232.4 төгрөгөөр тус тус өссөн.

Техник-эдийн засгийн үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв.

"ШИВЭЭ-ОВОО" ХК -ИЙН 2016 ОНЫ ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ							
Дд.	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2015 оны гүйцэтгэл	2016 он		Харьцуулсан %	
				төлөвлөгөө	гүйцэтгэл	төл-тэй	өнгөрсөн оны мөн үетэй
I	Эдийн засгийн үзүүлэлт						
1	Нүүрс олборлолт	м.тн	1,736.8	1,950.0	1,961.4	100.6	112.9
	Нүүрс борлуулалт	м.тн	1,817.8	1,950.0	1,880.9	96.5	103.5
	Хөрс хуулалт	м.м³	7,043.0	8,930.4	7,214.5	80.8	102.4
	Нийт уулын цул	м.м³	10,923.7	14,448.0	11,532.6	79.8	105.6
2	Нийт орлого:	м.төг	41,762,947.0	45,540,799.1	47,484,701.1	104.3	113.7
	Үүнээс Цэвэр борлуулалт	м.төг	37,759,707.2	44,886,924.1	42,744,255.8	95.2	113.2
	Нүүрсний илчлэгийн зөрүүгийн орлог	м.төг		417,000.0		-	#DIV/0!
3	Нийт зардал:	м.төг	41,112,848.9	46,700,540.8	44,951,455.0	96.3	109.3
	Удирдлагын зардал	м.төг	1,663,622.0	2,477,638.6	2,798,137.5	112.9	168.2
4	Татварын өмнөх ашиг (алдагдал)	м.төг	650,098.1	(1,159,741.7)	2,533,246.2	(218.4)	389.7
5	Төсвийн төлбөрт:	м.төг	6,383,459.6	7,224,309.6	7,228,700.1	100.1	113.2
	а) орлогын татвар	м.төг	65,009.8	-	253,324.6	#DIV/0!	389.7
	б) НӨАТ	м.төг	3,786,064.2	4,488,692.4	4,274,425.6	95.2	112.9
	в) Бусад татвар, төлбөрүүд	м.төг	2,532,385.6	2,735,617.1	2,700,949.9	98.7	106.7
6	Нийт авлага	м.төг	3,484,263.0	6,861,836.9	1,627,302.1	23.7	46.7
7	Нийт өглөг	м.төг	93,872,175.4	83,672,314.0	107,081,569.7	128.0	114.1
	Үүнээс богино хугацаат өглөг	м.төг	49,386,086.3	29,960,434.9	68,506,103.4	228.7	138.7
8	Сарын дундаж цалин	м.төг	1,072.6	1,233.9	1,212.6	98.3	113.1
9	1тн нүүрсний өөрийн өртөг	төг	18,663.5	23,461.5	20,249.8	86.3	108.5
10	1тн нүүрсний дундаж үнэ	төг	20,772.6	23,018.9	22,725.8	98.7	109.4
11	1м³ уулын цулын өртөг	төг	3,426.4	3,166.5	3,194.0	100.9	93.2
12	Нийт цалингийн сан	м.төг	6,821,853.9	8,810,327.2	8,469,111.0	96.1	124.1
13	Ажиллагчдын тоо	хүн	530	595	582	97.8	109.8
14	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	төг	0.93	1.02	0.89	87.4	95.8
15	ХО ба ТЗБАХэмжээ	м.төг	2,948,514.5	44,712,476.9	12,445,702.3	27.8	422.1
II	Түлш эрчим хүчний найдвартай байдал						
1	Аваар, осол / техникийн /	тоо	-	-	-	#DIV/0!	#DIV/0!
2	Хөрс хуулалтын коэффициент	м³/тн	4.1	4.6	3.7	80.0	90.7
3	Ус шүүрүүлэлт	м.куб	3,487.8	4,300.0	2,972.8	69.1	85.2
4	Нөхөн сэргээлтийн зардал	м.төг	56,366.0	126,274.0	49,609.6	39.3	88.0

Нүүрсний өөрийн өртгийг бүрдүүлж буй нийт зардлаас төлөвлөсөн хэмжээнээс 16 нэр төрлийн зардал 11,078.2 сая төгрөгөөр буурч, 5 нэр төрлийн зардал 4640.8 сая төгрөгөөр хэтэрсэн үзүүлэлттэй гарч дүнгээрээ 6,437.3 сая төгрөгөөр зардал хэмнэсэн байна. Үйлдвэрлэлийн зардлуудын хэлбэлзлийг төлөвлөгөө болон өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж **ҮЗВЭЛ:**

а) Хэтэрсэн зардлууд:

1. Тэсрэх материалын зардал төлөвлөсөн хэмжээнээс 14.1 хувь буюу 314.0 сая төгрөгөөр өссөн нь тэсрэх материалын зардлыг жилдээ 1667.6 мянган тн тэсрэх материалыг зарцуулахаас

1440.9 мянган тн-ыг зарцуулж, өрмийн машины зардал 513.1 сая төгрөгийг тэсрэх материалын өртөгт шингээсэнтэй холбоотой, цэвэр дүнгээрээ 199.1 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс тэсрэх материалын зардал 234.1 сая төгрөгөөр буурсан нь тээвэргүй хөрс хуулалт 300.7 мянган шоометрээр буурсантай холбоотой.

2. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, ус ашигласны төлбөр 114.2 сая төгрөгөөр өссөн нь газрын гүний ус шавхан зайлуулах гэрээгээр шүүрүүлсэн усны хэмжээгээр бус тухайн жилд төлөх усны төлбөрөөр тооцож ноогдуулсанаар 120.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

3. Хойшлогдох хөрс хуулалт 2016 онд 2331.5 мянган шоометр буюу 6.5 тэрбум төгрөгийн зардал гаргаж өртгөөс хасах байсан бол гүйцэтгэлээр 1139.8 мянган шоометр хөрс хуулж 3.6 тэрбум төгрөгийн зардал гаргаж, хөрс хуулалтын хойшлуулалтын зардал төлөвлөснөөс 2.8 тэрбум төгрөгөөр бага байна.

4. Элэгдлийн зардал 404.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2016 оны хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэлийн элэгдлийн зардалтай холбоотой. ХОТЗБАХ-ний төлөвлөгөөний элэгдлийн зардлыг төлөвлөөгүй.

5. Гэрээт ажлын хөлс 924.3 сая төгрөгөөр өссөн нь төлөвлөгөөнөөс АБХ-ийн ТАМ, хүнд машин механизмуудын эвдрэл 644.0 сая төгрөгөөр, УНХ-ийн УТТ-үүдийн эвдрэл 366.1 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой.

б) Хэмнэгдсэн зардлуудыг авч үзвэл:

1. Дизель түлшний зардал 36.5 хувь буюу 3260.9 сая төгрөгөөр буурсан байна. Дизель түлшний нэгжийн үнийн өөрчлөлтөөс $/(1650\text{төг}-1328\text{төг}) 321\text{ төг} \times 4405.6\text{ м.литр} = / 1418.6\text{ сая төгрөгөөр}$, биет хэмжээний зарцуулалтаас $/(5421.5\text{ м.литр}-4405.6\text{ м.литр}) 1015.9 \times 1328 = / 1349.1\text{ сая төгрөгөөр тус тус буурсан байна.}$

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 588.8 сая төгрөгөөр буурсан нь үнийн болон тоо хэмжээний бууралттай холбоотой.

2. Тос, тослох материалын зардал 0.7 хувь буюу 4.7 сая төгрөгөөр буурсан нь биет хэмжээгээр $/153.6\text{ гүйц} - 142.2\text{ төл}/ 11.4\text{ мянган литр илүү зарцуулж }53.4\text{ сая төгрөг, үнийн дүнгээр }58.1\text{ сая төгрөг буурсан зэрэгтэй холбоотой, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад }4.5\text{ хувь буюу }33.9\text{ сая төгрөгөөр буурсан байна.}$

3. Бензин шатахууны зардал 41.1 хувь буюу 37.6 сая төгрөгөөр хэмнэж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25.1 сая төгрөгөөр буурсан байна.

4. Цахилгаан эрчим хүчний зардал 23.5 хувь буюу 735.6 сая төгрөгөөр буурсан байна. Уулын цулын хэмжээ төлөвлөгөө 2915.4 сая м³-аар тасарснаас хамаарсан.

5. Сэлбэг хэрэгслийн зардал төлөвлөсөн хэмжээнээс 39.5 хувь буюу 4560.5 сая төгрөгөөр буурсан нь Актласан комацу автосамосвалын сэлбэгийг авч бусад машинд нь хэрэглэсэнтэй холбоотой.

Тус зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 346.7 сая төгрөгөөр өссөн нь өрмийн машины эвдрэл ихэссэнтэй холбоотой.

6. Дугуйн зардал 6.5 хувь буюу 60.6 сая төгрөгөөр буурсан шалтгаан нь биет хэмжээгээр технологийн автомашинуудын 23 ширхэг дугуйн хэмнэлт байна.

7. Вагон ашиглалтын зардал 6.5 хувь буюу 14.9 сая төгрөгөөр буурсан нь төлөвлөсөн хэмжээнээс нүүрс борлуулалтын хэмжээ 3.5 хувь буюу 69.1 мянган тонноор дутуу байсантай холбоотой.

8. Дулааны зардал 102.9 сая төгрөгөөр буурсан нь зуухнуудын урсгал ба их засварын зардалтай холбоотой.

9. Хөдөлмөр хамгааллын зардал төлөвлөсөн хэмжээнээс 132.9 сая төгрөгөөр буурсан нь нээлттэй сонгон шалгаруулалтаар төлөвлөсөн үнээс бага үнийн саналаар материал нийлүүлэгдсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 84.2 хувь буюу 195.2 сая төгрөгөөр өссөн байна.

10. Үйлдвэрлэлийн цалин хөлс НДШ 18.8 хувь буюу 751.3 сая төгрөгөөр буурсан нь уулын ажлын хэмжээтэй холбоотой.

Ажилчдын сарын дундаж цалин 1212.6 мянган төгрөг, нийт цалингийн сан 341.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Нийт цалингийн сан өнгөрсөн оны мөн үеийнхээс 24.1 хувь буюу 1647.3 сая төгрөгөөр, ажилчдын дундаж цалин 140.0 мян төгрөгөөр тус тус өсчээ.

11. Ашигт малтмал ашигласны төлбөр 53.6 сая төгрөгөөр буурсан нь борлуулалтын орлогын 2.1 тэрбум төгрөгийн бууралттай холбоотой.

12. Даатгалын зардал 115.7 сая төгрөгөөр буурсан нь 2016 оны даатгалын гэрээний гүйцэтгэлтэй холбоотой.

13. Нөхөн сэргээлтийн зардал 76.7 сая төгрөгөөр буурсан нь төлөвлөсөн га-д нөхөн сэргээлт хийгээгүй.

14. Бусад зардал 28.9 сая төгрөгөөр буурсан нь зөвлөх үйлчилгээний зардлыг бичээгүйтэй холбоотой байна.

"ШИВЭЭ-ОВОО" ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ						
Дд.	Үзүүлэлтүүд	Х Э М Н Э	2015 оны гүйцэтгэл	2016 оны төлөвлөгөө	2016 оны гүйцэтгэл	Хэлбэлзэл төл-с %
А.Уулын ажлын үзүүлэлт						
1	Нүүрс борлуулалт	м	1,817.8	1,950.0	1,880.9	96.5
2	Нүүрс олборлолт	м	1,736.8	1,950.0	1,961.4	100.6
3	Тээвэртэй хөрс хуулалт	м	4,955.5	6,971.1	5,427.7	77.9
4	Тээвэргүй хөрс хуулалт	м	2,087.5	1,959.3	1,786.8	91.2
5	дахин шидэлт	м	1,239.7	3,456.1	2,033.7	58.8
6	Нийт хөрс хуулалт	м	7,043.0	8,930.4	7,214.5	80.8
7	Инженер ажил	м	1,205.9	1,736.3	663.4	38.2
8	Нийт уулын цул	м	10,923.7	14,448.0	11,532.6	79.8
Б.Өртөг зардлын үзүүлэлт						
1	Тэсрэх материал	м	2,781,316.4	2,233,193.8	2,547,227.3	114.1
2	Дизелийн түлш	м	6,270,870.2	8,943,037.1	5,682,048.3	63.5
3	Бензин	м	79,048.4	91,590.0	53,931.1	58.9
4	Тос, тослох материал	м	746,133.9	716,950.9	712,212.9	99.3
5	Цахилгаан	м	1,722,795.7	3,128,322.3	2,392,712.1	76.5
6	Вагон ашиглалт	м	196,334.1	227,780.6	212,900.2	93.5
7	Дулаан	м	48,770.0	169,443.9	66,508.9	39.3
8	Дугуйн зардал	м	562,889.2	932,840.0	872,183.1	93.5
9	Сэлбэг	м	6,647,892.4	11,555,120.8	6,994,560.2	60.5
10	Хөдөлмөр хамгаалал	м	231,841.6	560,046.8	427,072.5	76.3
11	Цалин	м	5,713,105.1	7,405,354.9	6,749,318.8	91.1
12	НДШ	м	774,932.7	962,696.1	867,390.4	90.1
13	АМНөөц	м	948,783.3	1,122,173.1	1,068,606.4	95.2
14	ҮХХАТ, УАТ, АТӨЯХАТ	м	808,669.6	650,747.9	764,953.1	117.5
15	ҮХ-н элэгдэл	м	6,517,886.1	6,870,777.8	7,275,591.0	105.9
16	Зээлийн хүү	м	1,230,807.0	1,141,093.3	-	-
17	Хөрс хуулалтын хойшлуулалт	м	(6,376,868.6)	(6,553,969.2)	(3,670,538.9)	56.0
18	Даатгалын зардал	м	124,350.4	180,506.7	64,830.9	35.9
19	Нөхөн сэргээлтийн зардал	м	56,366.0	126,274.0	49,609.6	39.3
20	Гэрээт ажлын хөлс	м	1,407,052.5	2,196,378.7	3,120,716.7	142.1
21	Бусад зардал	м	505,632.7	612,013.4	583,183.9	95.3
22	Өөрийн өртөг	м	37,428,868.3	43,272,372.9	36,835,018.6	85.1
23	Удирдлагын зардал	м	1,663,622.0	2,477,638.6	2,798,137.5	112.9
24	Борлуул өөрийн өртөг	м	33,925,853.2	45,750,011.5	38,087,250.7	83.3
В. Орлогын үзүүлэлт						
1	Борлуулалтын орлого	м	37,759,707.2	44,886,924.1	42,744,255.8	95.2
2	Нүүрсний илчлэгийн зөрүүгийн орлого	м	-	417,000.0	-	-
3	Борлуулалтын ашиг	м	3,833,854.0	(446,087.3)	4,657,005.2	(1,044.0)
4	Үйл/аж бус орлого	м	4,003,239.9	236,875.0	4,740,445.3	2,001.2
5	Үйл/аж бус зардал	м	7,186,995.7	950,529.4	6,864,204.3	722.1
6	Үйл/аж бус ашиг	м	(3,183,755.8)	(713,654.4)	(2,123,759.0)	297.6
7	Татварын өмнөх ашиг	м	650,098.1	(1,159,741.7)	2,533,246.2	(218.4)

**“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРОО**

2017 оны 03-р сарын 23-ны өдөр

№01

Улаанбаатар хот

**2016 ОНЫ ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ,
САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТЭНЦЭЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ, САНАЛ**

“Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос “Шивээ Овоо” ХК-ийн 2016 оны санхүүгийн жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас эрх авч сонгогдсон аудитын “Есөнхангай аудит” ХХК нь Шивээ-Овоо ХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж болон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шудрага илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргасан байна.

НЭГ : ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

“Шивээ-Овоо ” хувьцаат компани 2016 онд 7,214.5 мян.м3 хөрс хуулж төлөвлөгөөг 80,8 хувиар буюу 1,715.9 мян.м3 - ээр дутуу хуулсан байна. Тээвэртэй хөрс хуулалт 77.9 хувь, тээвэргүй хөрс хуулалт 91.2 хувийн тус тус биелэлттэй байна.

“Шивээ-Овоо ” хувьцаат компани нь тайлант хугацаанд 1,961.4 мян.тонн нүүрс олборлож төлөвлөгөөг 100.6 хувиар, 1,880.9 мян.тонн нүүрс борлуулж төлөвлөгөөг 96.5 хувиар тус тус биелүүлсэн байна. Нүүрс борлуулалтын төлөвлөгөө 69.1 мян. тонн-оор тасарсан байна.

Нүүрс борлуулалтын орлого

Хэрэглэгчдэд нийлүүлсэн нүүрсний хэмжээ / мянган тонноор /

Хэрэглэгчид	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Эзлэмж
ДЦС-IV ТӨХК	1680	1631,1	-48,9	97,1%	86,8%
УБ Төмөр зам	45	39	-6	86,7%	2,1%
Бор өндөр УБҮ	38	37,6	-0,4	98,9%	2,0%
Дорноговь ЭХНҮ	33	32,7	-0,3	99,1%	1,7%
Чандмань бадрал ЭХНҮ	28,4	12,3	-16,1	43,3%	0,7%
Налайх ДС	10	13,1	3,1	131,0%	0,7%
Говьсүмбэр	14	14,2	0,2	101,4%	0,8%
Амгалан ДС	46,7	48,4	1,7	103,6%	2,6%
Бусад	54,9	49,7	-5,2	90,5%	2,6%
Дүн	1950	1878,1	-71,9	96,3%	100,0%

2016 онд нэг тонн нүүрсийг дунджаар 22,725.0 төгрөгөөр борлуулсан байна. Төлөвлөсөн дундаж үнэ 23,018.9 төгрөг. Энэ нь биетээр бага борлуулснаас 1,590.6 сая төгрөг, үнийн зөрүүгээс 551.9 сая төгрөгөөр борлуулалтын орлого тасарсан байна.

**ХОЁР: САНХҮҮГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

Үйл ажиллагааны үр дүнгийн талаар:

2016 онд бизнес төлөвлөгөөгөөр нийт 45,540.8 сая төгрөгийн борлуулалт хийж 46,700.5 сая төгрөгийн зардал гарган 1,159.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөгдсөн.

2016 онд үндсэн үйл ажиллагаанаас 42,744.2 сая төгрөгийн орлого олж 38,087.2 сая төгрөгийн зардал гарган 4,657.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж, үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанаас 4,740.4 сая төгрөгийн орлого олж 6,864.2 сая төгрөгийн зардал гарган 2,123.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллан, нийт дүнгээрээ 2,533.2 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Зардал хэмнэсэн шалтгаан: Төлөвлөсөн уулын цулын хэмжээ 2,9 сая м³ –ээр тасарсан нь зардал хэмнэх үндэс болсон.

Нүүрсний өөрийн өртгийг бүрдүүлж буй нийт зардлаас төлөвлөсөн хэмжээнээс 16 нэр төрлийн зардал 11,078.2 сая төгрөгөөр буурч, 5 нэр төрлийн зардал 4,640.8 сая төгрөгөөр хэтэрсэн үзүүлэлттэй гарч дүнгээрээ 6,437.3 сая төгрөгөөр зардал хэмнэсэн байна. Уулын ажлын хэмжээ төлөвлөснөөс буусан учир харьцуулалтыг 1 м³ уулын цулаар хийж өртөг зардлыг үнэлэх нь зөв юм.

2016 он 1 м3 уулын цулын өртөг 3,194.0 төгрөг байсан ба төлөвлөгөөнөөс 0,9 хувиар өссөн харин өнгөрсөн мөн үеийнхтэй харьцуулахад 6,8 хувиар бага байна.

Тэсрэх материалын зардал төлөвлөсөн хэмжээнээс 14.1 хувь буюу 314.0 сая төгрөгөөр өссөн нь тэсрэх материалын зардлыг жилдээ 1667.6 мянган тн тэсрэх материалыг зарцуулахаас 1440.9 мянган тн-ыг зарцуулж, өрмийн машины зардал 513.1 сая төгрөгийг тэсрэх материалын өртөгт шингээсэнтэй холбоотой, цэвэр дүнгээрээ 199.1 сая төгрөгөөр буурсан байна.

Шалтгаан: Өмнөх оны мөн үеийнхээс тэсрэх материалын зардал 234.1 сая төгрөгөөр буурсан нь тээвэргүй хөрс хуулалт 300.7 мянган шоометрээр буурсантай холбоотой.

Элэгдлийн зардал 404.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2016 оны хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний гүйцэтгэлийн элэгдлийн зардалтай холбоотой. ХОТЗБАХ-ний төлөвлөгөөний элэгдлийн зардлыг төлөвлөөгүй.

Удирдлагын үйл ажиллагааны зардлын талаар: Удирдлагын үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 12.9 хувь буюу 320.5 сая төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеийнхээс 68.2 хувь буюу 1134.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Цахилгаан, дулааны зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн шимтгэл, хөдөлмөр хамгаалал, түрээсийн зардал хэтэрсэн байна.

Авлага, өглөгийн талаар: Компанийн нийт авлага 4818,3 сая төгрөг болж оны эхнээс 47,6 хувиар буюу 1504,4 сая төгрөгөөр буурсан. Авлагын 44 хувийг ДЦС-4 ТӨХК-аас авах авлага, 18 хувийг бусад төрийн болон орон нутгийн өмчит ДС-уудаас авах авлага эзэлж байна. Шүүхийн шийдвэр гарсан боловч хэрэгжээгүйгээс үүдсэн авлага 320,1 сая буюу нийт авлагын 7 хувийг эзэлж байна.

Богино хугацаат өглөгийн хэмжээ 68 506, 1 сая төгрөг болж оны эхнээс 38,7 хувиар буюу 19120,0 сая төгрөгөөр нэмэгдсэн. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь Санхүүгийн түрээсийн өглөг оны эхнээс 17689,2 төгрөгөөр нэмэгдсэнтэй шууд холбоотой юм.

Мөнгөн хөрөнгийн хомсдлоос шалтгаалан Сангийн яаманд төлөх зээлийн хүүгийн өглөг 3317,0 сая төгрөгөөр, Нийт зардлын 3-н хувиар менежментийн төлбөр төлөхөөр тооцсноос толгой компанид /Эрдэнэс Монгол ХХК/ төлөх өглөг 1763,6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Мөн ДЦС-4 ТӨХК-ийн оны эцсийн төлбөр он дамжин орж ирснээс 800,0 сая төгрөгийн өглөгийн бууралт тайланд тусгагдаж амжаагүй болно. Дээр дурдсан өглөгүүдээс бусад богино хугацаа өглөгийг 4449,8 сая төгрөгөөр бууруулан ажилласан.

Аудитын тайланд дурдагдсан зөрчил дутагдлын талаар: Аудитын дүгнэлтийн "Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар" гэсэн хэсэгт тайлан гаргасан

Аудитын байгууллага нийт 17 зөрчил, дутагдал илрүүлж, тэдгээрээс 11 зөрчил, дутагдлыг “Шивээ-Овоо” ХК-ийн зүгээс хүлээн зөвшөөрч шийдвэрлэсэн буюу залруулга хийсэн тухай өгүүлжээ.

Харин Компанийн зүгээс Аудитын тайланд дурдагдсан бөгөөд шийдвэрлэгдээгүй шаардлага, зөвлөмж өгөгдсөн дараах асуудлаар тайлбар буюу мэдээлэл танилцуулах шаардлагатай байна. Үүнд:

1. "Бараа үйлчилгээ худалдан авахдаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 8.1.1, 8.4, 33.1, болон 34 дүгээр зүйл зөрчигдсөн тухайд (Тайлангийн 9-р хуудас);
2. Дотоод хяналт гэсэн хэсэгт байгууллагын дотоод хяналт сул байгаа (Тайлангийн 6-р хуудас);
3. Шилэн дансны мэдээлэл гэсэн хэсэгт Компани шилэн дансны цахим хуудаст ямарч мэдээлэл оруулаагүй тухайд (Тайлангийн 7-р хуудас);
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, болон 20.2.6-г тус тус хэрэгжүүлээгүй, мөн тус хуулийн 5.1.4-ийг зөрчсөн тухайд зэрэг болно.

ДҮГНЭЛТ, САНАЛ:

“Шивээ-Овоо” хувьцаат компани 2016 оны зорилтот түвшний биелэлт, санхүүгийн тайлангийн дүнд дүгнэлт хийж цаашид дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Аудитын тайланд дурдагдсан хууль тогтоомжийн зөрчлийн талаар өөрийн тайлбар, мэдээллийг ТҮЗ-д танилцуулах;
2. Зөрчил дутагдлын шалтгааныг зөв тогтоож, зөрчлийг арилгахад шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллаж үр дүнг дүгнэх;
3. Санхүү, нягтлан болох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд сургалт, техник, технологийг сайжруулах шаардлага байгаа эсэхийг судлан тогтоож танилцуулах;
4. Зардал бүрийг уулын ажлын хэмжээ болон үнийн дүнгийн зөрүүнээс хэтэрсэн хэмнэснийг тодорхойлж гаргаж байх;
5. Аудиын тайланд дотоод хяналт сул байна гэж дүгнэсэн байна. Мөн энэ нь төлөвлөлтийн сахилга бат алдагдсныг харуулж байна. Иймд дотоод хяналт болон төлөвлөлтийн сахилга батыг сайжруулах;
6. Шилэн дансны мэдээллийг тогтмол оруулж байх ажлын төлөвлөгөө боловсруулж хариуцах эзэнтэй болгох;
7. Цаашид төлөвлөлтийн сахилга батыг сайжруулж уулын ажлын төлөвлөгөөг мөрдөж ажиллах;
8. Томоохон зардлуудад /түлш, тэсрэх материал, сэлбэг хэрэгсэл гэх мэт/ өнгөрсөн 5 жилийн судалгааг хийж үнийн эрсдэлийн төвшинг тогтоох, төлөвлөлтийг сайжруулах;
9. 2016 оны эхний хагас жилийн аудитын хорооны зөвлөмж саналын дагуу хийж хэрэгжүүлсэн ажлуудыг тайлагнах зэрэг болно

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРОО



“ШИВЭЭ ОВОО” ХК -ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ О.ОТГОНБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03. 21 № 3/502
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шивээ овоо” ХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Шивээ овоо” ХК-ийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдлөг болгож, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

“Шивээ овоо” ХК –ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмаар санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Шивээ овоо” ХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд илэрхийлсэн өмч, хөрөнгийн үлдэгдэл, үйл ажиллагааны үр дүн, ажил гүйлгээний мөнгөн дүн, хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, хууль тогтоомжуудын мөрдөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлсийг түүвэр сорилоор шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Тус компани нь бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.”, 8.4. “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, 33.1. “Бараа, ажил,

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2017\0321SAG4.Docx

070785

үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.”, 34 дүгээр зүйлийн гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх зэрэг нөхцлүүдийг зөрчсөн, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй, 13,097.0 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол санхүүгийн тайлангууд нь “Шивээ овоо” ХК -ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	(төгрөгөөр)		
	Тайлангаарх дүн		Аудитлагдсан дүн
	2015 онд	2016 онд	2016 онд
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	41,616,764,100.00	42,300,490,611.01	42,300,490,611.01
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	40,943,880,700.00	41,439,880,308.37	41,439,880,308.37
Туслах үйл ажиллагаанаас олсон орлого	568,042,800.00	860,610,302.64	860,610,302.64
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	104,840,600.00	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	39,390,528,503.80	38,638,328,383.61	38,638,328,383.61
Ажиллагсад төлсөн	7,708,981,100.00	6,192,843,925.43	6,192,843,925.43
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,635,302,000.00	2,074,942,452.00	2,074,942,452.00
Бараа материал худалдан авахад төлсөн	16,562,932,300.00	17,613,866,437.56	17,613,866,437.56
Ашиглалтын зардалд төлсөн	8,566,264,900.00	6,602,597,647.06	6,602,597,647.06
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	339,328,938.00	-	-
ТУЗ, томилолт бусад зардал	-	261,149,742.10	261,149,742.10
Хүүний төлбөрт төлсөн	392,230,400.00	533,295,741.59	533,295,741.59
Татварын байгууллагад төлсөн	3,183,172,000.00	4,359,190,782.21	4,359,190,782.21
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	57,765,116.21	57,765,116.21
Бусад мөнгөн зарлага	1,002,316,865.80	942,676,539.45	942,676,539.45
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,226,235,596.20	3,662,162,227.40	3,662,162,227.40
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	1,152,200.00	438,525,227.00	438,525,227.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,152,200.00	438,525,227.00	438,525,227.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,722,246,000.00	3,235,000,000.00	3,235,000,000.00
Үндсэн хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн	1,572,246,000.00	3,235,000,000.00	3,235,000,000.00
Хөрөнгө оруулалт олж, эзэмшихэд төлсөн	150,000,000.00	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,721,093,800.00)	(2,796,474,773.00)	(2,796,474,773.00)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	5,459,542,200.00	5,617,110,075.75	5,617,110,075.75
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,454,000,000.00	5,612,458,381.46	5,612,458,381.46
Төрөл бүрийн хандив	5,300,000.00	-	-
Валютын ханшийн зөрүү	242,200.00	4,651,694.29	4,651,694.29
Мөнгөн зарлагын дүн (-)	5,042,902,800.00	6,899,730,467.17	6,899,730,467.17
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,229,811,600.00	6,488,110,933.78	6,488,110,933.78
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	2,807,780,000.00	55,200,000.00	55,200,000.00
Төрөл бүрийн хандив	-	28,305,788.00	28,305,788.00
Хүүгийн зардалд	-	328,113,745.39	328,113,745.39
Валютын ханшийн зөрүү	5,311,200.00	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	416,639,400.00	(1,282,620,391.42)	(1,282,620,391.42)
БУХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	921,781,196.20	(416,932,937.02)	(416,932,937.02)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,121,415,638.00	2,043,196,834.20	2,043,196,834.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,043,196,834.20	1,626,263,897.18	1,626,263,897.18

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлангаарх үлдэгдэл		(төгрөгөөр)	
	01-р сарын 01	12 -р сарын 31	Аудитын залруулга	Аудитлагдсан үлдэгдэл 12 -р сарын 31
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,043,196,834.20	1,626,263,897.18	-	1,626,263,897.18
Дансны авлага	3,131,702,962.85	1,627,302,144.28	30,794,812.86	1,596,507,331.42
Татвар, НДШ -ийн авлага	352,560,042.14	-	(10,225,896.43)	10,225,896.43
Бусад авлага	-	-	(1,268,236,156.64)	1,268,236,156.64
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	-
Бараа материал	10,852,537,772.57	14,105,977,094.49	99,126,646.89	14,006,850,447.60
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	1,773,345,348.18	2,586,877,940.07	274,400,870.00	2,312,477,070.07
Эргэлтийн хөрөнгийн дүн	18,153,342,959.94	19,946,421,076.02	(874,139,723.32)	20,820,560,799.34
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	57,273,813,863.71	69,499,490,235.37	(143,508,046.09)	69,642,998,281.46
Хөрс хуулалтын хөрөнгө	21,082,229,544.57	24,752,768,431.94	-	24,752,768,431.94
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	-	-
Хойшлогдсон хөрс хуулалтын шавхагдал	(1,480,803,734.42)	(1,871,222,945.66)	-	(1,871,222,945.66)
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	530,131,395.36	530,131,395.36	-	530,131,395.36
Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,991,112,937.00	1,304,460,207.09	-	1,304,460,207.09
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	80,396,484,006.22	94,215,627,324.10	(143,508,046.09)	94,359,135,370.19
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	98,549,826,966.16	114,162,048,400.12	(1,017,647,769.41)	115,179,696,169.53
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	16,549,755,278.53	18,956,136,898.93	(1,418,427,586.89)	20,374,564,485.82
Цалингийн өглөг	245,259,488.15	296,388,886.57	-	296,388,886.57
Татвар, ЭМД, НДШ -ийн өр	1,449,022,186.16	1,227,076,653.58	48,888,297.64	1,178,188,355.94
Богино хугацаат зээл	2,216,666,666.50	-	-	-
Урьдчилж орсон орлого	99,331.81	-	-	-
Хүүний өглөг	425,286,231.69	317,149,520.07	-	317,149,520.07
Засгийн газрын дэмжлэг	3,111,820,512.00	3,637,483,376.00	-	3,637,483,376.00
Санхүүгийн түрээсийн өглөг	2,224,930,225.60	5,061,669,186.60	-	5,061,669,186.60
Бусад богино хугацаат өр төлбөр	23,163,246,343.74	26,526,442,965.92	-	26,526,442,965.92
Ногдол ашгийн өглөг	-	130,419,101.00	-	130,419,101.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	49,386,086,264.18	56,152,766,588.67	(1,369,539,289.26)	57,522,305,877.92
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	18,671,920,262.42	16,544,200,248.18	0.01	16,544,200,248.18
Засгийн газрын дэмжлэг	22,838,290,403.69	20,392,768,722.69	-	20,392,768,722.69
Ажилчдын тэтгэвэрийн сан	1,056,906,953.00	1,279,932,677.93	12,311,753.41	1,267,620,924.52
Санхүүгийн түрээсийн өглөг	1,560,406,840.13	10,502,656,315.95	0.01	10,502,656,315.94
Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг	-	2,104,005,152.60	(124,472,727.20)	2,228,477,879.80
Хойшлогдсон татварын өр	358,564,643.00	358,564,643.00	-	358,564,643.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	44,486,089,102.24	51,182,127,760.35	(112,160,973.76)	51,294,288,734.12
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	93,872,175,366.42	107,334,894,349.02	(1,481,700,263.02)	108,816,594,612.04
ЭЗДИЙН ӨМЧ				
Өмч : -Төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00	-	1,207,710,000.00
-Хувийн	-	-	-	-
-Хувьцаат	134,190,000.00	134,190,000.00	-	134,190,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
Хуримтлагдсан ашиг	3,335,751,599.74	5,485,254,051.10	464,052,493.61	5,021,201,557.49
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,677,651,599.74	6,827,154,051.10	464,052,493.61	6,363,101,557.49
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	98,549,826,966.16	114,162,048,400.12	(1,017,647,769.41)	115,179,696,169.53

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Тайлангаарх дүн		(төгрөгөөр)	
	01-р сарын 01	12 -р сарын 31	Аудитын залруулга	Аудитлагдсан дүн 12 -р сарын 31
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	37,759,707,164.85	42,752,185,435.10	-	42,752,185,435.10
Борлуулалтын өртөг	32,262,231,231.00	35,289,113,128.58	111,297,625.00	35,177,815,503.58
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	5,497,475,933.85	7,463,072,306.52	(111,297,625.00)	7,574,369,931.52
Бусад орлого	4,003,239,877.00	3,145,926,388.65	-	3,145,926,388.65
	4,003,239,877.00	3,145,926,388.65	-	3,145,926,388.65
Борлуулалт маркетингийн зардал				
Ерөнхий ба удирдлагын зардал	1,663,622,008.78	2,877,088,466.03	34,334,832.86	2,842,753,633.17
Санхүүгийн зардал	164,389,100.00	-	-	-
Хүүгийн зардал	991,818,222.80	4,189,150,683.80	-	4,189,150,683.80
Бусад зардал	6,030,788,365.36	1,009,513,376.01	(170,047,138.20)	1,179,560,514.21
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/ гарз/			186,309,345.90	(186,309,345.90)
	8,850,617,696.94	8,075,752,525.84	50,597,040.56	8,397,774,177.08
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	650,098,113.91	2,533,246,169.33	(161,894,665.56)	2,322,522,143.09
Орлогын татварын зардал	65,009,811.39	253,324,616.93	(16,189,466.56)	232,252,214.31
ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)	585,088,302.52	2,279,921,552.40	(145,705,199.00)	2,090,269,928.78
Хойшлогдсон ОАТ-ын зардал				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	585,088,302.52	2,279,921,552.40	(145,705,199.00)	2,090,269,928.78
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
ОРЛОГЫН НИЙТ ДҮН	585,088,302.52	2,279,921,552.40	(145,705,199.00)	2,090,269,928.78

НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ
(АЛДАГДАЛ)

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)				
ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2015 оны 01 -р сарын 01 -ий үлдэгдэл	1,341,900,000.00	20,329,391,486.41	11,964,340,100.26	9,706,951,386.15
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(20,329,391,486.41)	14,715,003,397.07	(5,614,388,089.34)
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	0.00	2,750,663,296.81	4,092,563,296.81
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			585,088,302.52	585,088,302.52
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2015 оны 12 -р сарын 31 -ий үлдэгдэл	1,341,900,000.00		3,335,751,599.74	4,677,651,599.74
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(274,400,870.01)	(274,400,870.01)
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00		3,061,350,729.73	4,403,250,729.73
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			2,090,269,928.78	2,090,269,928.78
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг			(130,419,101.02)	(130,419,101.02)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2016 оны 12 -р сарын 31 -ий үлдэгдэл	1,341,900,000.00		5,021,201,557.49	6,363,101,557.49

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны зардлын гүйцэтгэл
2016 оны зардлын төсөв

Дд.	Зардлын төрөл	Хэмжих нэгж	2016 оны		2017 оны
			төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө
1	Цалин хөлс НДШ	м.төг	63,867.6	51,637.7	90,309.6
2	Унааны зардал	м.төг	1,100.0	552.3	1,100.0
3	Хоолны зардал	м.төг	600.0	1,083.7	600.0
4	Томилолт	м.төг	700.0	700.0	1,728.0
5	Сургалт	м.төг	500.0		500.0
6	Бичиг хэрэг	м.төг	1,000.0		1,000.0
7	Хувьцаа эзэмшигчдийн хурал бүртгэл судалгаа	м.төг	5,000.0	3,398.7	5,000.0
8	Бусад	м.төг	20,000.0	475.1	10,000.0
	Дүн	м.төг	92,767.6	57,147.4	110,237.6
	Гишүүд	Хүн	9	9	9

2017 оны төлөвлөгөөний талаар:

- ТУЗ-ийн хурлыг Улаабаатар хотод 10 удаа, компани дээр 2 удаа зохион байгуулна.
- ТУЗ нь дүрмийн дагуу 9 гишүүнтэй ажиллаж ТУЗ-ийн дарга сард 480,0, гишүүд 460,0 мянган төгрөгийн цалинтай байна.

---oOo---

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн 2016 оны
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ Овоо” ХК-ийн санхүүгийн тайлан тэнцлийн дүн түүнд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлт мэдээлэлээр сая төгрөгийн ашигтай ажилласан байх тул компанийн санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж тооцсугай.

2. “Шивээ овоо” ХК-ийн 2016 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг сая төгрөг Үүнээс:

- А. Эргэлтийн хөрөнгийг сая төгрөг
- Б. Биет үндсэн хөрөнгийг сая төгрөгөөр
- В. Биет бус хөрөнгийг сая төгрөгөөр
- Г. Урт хугацааны хөрөнгө оруулалтыг сая төгрөгөөр
- Д. Урт хугацаат өр төлбөрийг сая төгрөгөөр
- Е. Төрийн өмчийн дүнг сая төгрөгөөр
- Ё. Эзэмшигчдийн өмчийн бусад хэсгийг сая төгрөгөөр
- Ж. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүнг сая төгрөгөөр
- З. Хуримтлагдсан алдагдалыг сая төгрөгөөр
- И. Богино хугацаат өр төлбөрийг сая төгрөгөөр
- Й. Тайлант үеийн ашиг/ алдагдалыг..... сая төгрөгөөр тус тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ Овоо” ХК –ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг **110,237.6** сая төгрөгөөр тогтоож хавсралтын дагуу баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны
тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ Овоо” ХК-ийн 2016 оны үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг зөвшөөрч, компанийн 2016 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

**“ШИВЭЭ ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр
сарын 28-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалтын дагуу 2017 оны 04 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг 1 дүгээр хавсралтаар Хараат бус гишүүдийг 2 дугаар хавсралтаар 2016 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 сарын 28-ны
Өдрийн дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд
хувьцаа эзэмшигчдийг төлөөлөх гишүүд**

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил

Хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 сарын 28-ны
Өдрийн дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**“Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн хараат бус гишүүд**

Д/д	Гишүүдийн нэр	Үндсэн ажил

---oOo---

ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 81.2 дахь заалтыг үндэслэн “Шивээ Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Тавигдах шаардлага:

1. Уул уурхайн салбарт ажиллаж байсан туршлагатай, тухайн салбараар мэргэшсэн байх;
2. Эдийн засагч, Нягтлан бодох бүртгэл, Эрх зүйч мэргэжилтэй байх;
3. Сүүлийн 3 жилийн хугацаанд тус компанид эрх бүхий албан тушаал хашаагүй байх, мөн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч аж ахуйн нэгж байгууллагад ажилладаггүй байх;
4. Компанитай нэгдмэл сонирхолгүй бөгөөд нэгдмэл сонирхолтой этгээдийг төлөөлдгүй байх;
5. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бусад гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй байх;
6. Компанийн томоохон хэрэглэгчийн хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш байх/ нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активийн 10 хувиас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/;
7. Нэр дэвшигч өөрөө эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх;
8. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх;

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХЫГ ХЯЗГААРЛАХ НӨХЦӨЛ:

- Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан,
- Төрийн захиргааны болон төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт
- Төрийн албан хаагчийн анкет
- Боловсролын диплом, үнэмлэх
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангасан тухай гараар бичсэн баталгаа

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Чингисийн өргөн чөлөө-15 Моннис Цамхаг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн байр 15 давхарт, Шивээ Овоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад авчирч өгнө үү . утас:99068713,

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА:

2017 оны 04 сарын 25-ны өдөр хүртэл